



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/177/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn Булган
аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: : enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: tseb.audit@gmail.com

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 168
танай _____ ны № _____ т

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 183,403.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 30,891.4 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээс 29,419.9 мянган төгрөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч хөрөнгийг санхүүгийн тайланд тайлагнаж, тодруулсан байна.

006020387

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус сургуулийн төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар нь 3 удаа өөрчлөгдсөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>113,720,129.03</u> | <u>254,527,331.88</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 52,812,326.94 | 183,402,972.19 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 52,812,326.94 | 183,402,972.19 |
| 3121 | Төгрөг | 52,812,326.94 | 183,402,972.19 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 52,812,326.94 | 183,402,972.19 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 60,907,802.09 | 71,124,359.69 |
| 351 | Түүхий эд материал | 4,392,050.00 | 1,974,909.60 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,392,050.00 | 1,974,909.60 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,642,700.00 | 1,642,700.00 |
| 354 | Хангамжийн материал | 54,873,052.09 | 67,506,750.09 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 660,400.00 | 1,777,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,575,902.09 | 46,062,402.09 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 10,993,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | | |
| 35460 | Хүнсний материал | 3,070,850.00 | 76,248.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,565,900.00 | 8,597,600.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>4,270,414,786.03</u> | <u>4,348,892,440.82</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,270,414,786.03 | 4,348,892,440.82 |
| 392 | Биет хөрөнгө | 4,146,588,952.53 | 4,214,290,307.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,186,400,000.00 | 4,186,400,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (284,907,777.56) | (354,681,110.84) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 234,559,527.02 | 380,197,427.02 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (79,462,918.48) | (154,541,869.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 115,008,096.00 | 132,278,093.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (41,595,746.68) | (65,429,249.94) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 125,500.00 | 125,500.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,565,760.00 | 10,565,760.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,226,304.00) | (8,980,896.00) |
| 39217 | Ном | 10,122,816.23 | 88,356,653.73 |
| 393 | Биет бус хөрөнгө | 123,825,833.50 | 134,602,133.32 |
| 39301 | Програм хангамж | 2,030,000.00 | 13,678,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (904,166.50) | (1,775,866.68) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>4,384,134,915.06</u> | <u>4,603,419,772.70</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>3,521,100.00</u> | <u>7,823,470.28</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,521,100.00 | 7,823,470.28 |
| 413 | Өглөг | 3,521,100.00 | 7,823,470.28 |

| | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 479,628.28 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 1,295,946.00 |
| 4136 | Бусад өглөг | 3,521,100.00 | 6,047,896.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,375,200.00 | 2,863,296.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 2,145,900.00 | 3,184,600.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,380,613,815.06 | 4,595,596,302.42 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,380,613,815.06 | 4,595,596,302.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 122,700,000.00 | 122,700,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 4,257,913,815.06 | 4,472,896,302.42 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,257,913,815.06 | 4,215,264,941.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 257,631,360.95 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,384,134,915.06 | 4,603,419,772.70 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,333,876,895.00 | 1,761,095,996.10 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 13,025,695.00 | 224,580,796.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 13,025,695.00 | 224,580,796.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 13,025,695.00 | 224,580,796.10 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,025,695.00 | 224,580,796.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,320,851,200.00 | 1,536,515,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 990,503,700.00 | 1,232,854,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 990,503,700.00 | 1,232,854,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 330,347,500.00 | 303,661,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 330,347,500.00 | 303,661,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,267,056,517.56 | 1,503,361,135.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,267,056,517.56 | 1,503,361,135.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,229,195,144.50 | 1,464,747,903.47 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 721,507,621.48 | 862,107,850.71 |
| 210101 | Үндсэн цалин | 534,252,021.94 | 651,721,116.42 |
| 210102 | Нэмэгдэл | 154,362,768.84 | 183,233,121.14 |
| 210104 | Урамшуулал | 32,892,830.70 | 27,153,613.15 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 86,343,178.46 | 100,893,566.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,713,361.35 | 69,246,942.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,907,454.28 | 8,057,085.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,525,963.42 | 6,956,927.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,381,490.86 | 1,861,115.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,814,908.55 | 14,771,495.73 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 282,831,001.00 | 285,208,480.32 |

| | | | |
|-------------|---|-----------------------------|------------------------------|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,196,701.00 | 21,592,013.98 |
| 210302 | Түлш, халаалт | 247,448,608.00 | 241,889,532.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,185,692.00 | 21,726,934.34 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,822,860.00 | 1,261,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 1,101,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,139,360.00 | 160,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,739,395.00 | 46,315,264.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48,300.00 | 251,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,451,095.00 | 46,063,664.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,547,670.00 | 5,424,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,547,670.00 | 5,424,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,284,020.00 | 4,736,890.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,284,020.00 | 4,736,890.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 93,119,398.56 | 158,799,852.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,070,650.00 | 18,886,506.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,182,700.00 | 8,123,640.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 57,866,048.56 | 131,789,706.12 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 37,861,373.06 | 38,613,231.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,861,130.00 | 38,108,712.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 37,861,130.00 | 38,108,712.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 243.06 | 504,519.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 243.06 | 504,519.68 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>66,820,377.44</u> | <u>257,734,860.95</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 103,500.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (103,500.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>66,820,377.44</u> | <u>257,631,360.95</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,320,851,200.00</u> | <u>1,536,515,200.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | <u>1,320,851,200.00</u> | <u>1,536,515,200.00</u> |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 990,503,700.00 | 1,232,854,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 990,503,700.00 | 1,232,854,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 330,347,500.00 | 303,661,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 330,347,500.00 | 303,661,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,210,068,874.00</u> | <u>1,378,521,054.75</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | <u>1,210,068,874.00</u> | <u>1,378,521,054.75</u> |

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,167,125,680.94 | 1,340,718,849.07 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 719,950,928.76 | 860,765,822.43 |
| 210101 | Үндсэн цалин | 536,734,787.92 | 643,351,904.42 |
| 210102 | Нэмэгдэл | 150,323,310.14 | 187,183,193.24 |
| 210104 | Урамшуулал | 32,892,830.70 | 30,230,724.77 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,899,871.18 | 100,893,566.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,859,015.73 | 69,246,942.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,385,610.88 | 8,057,085.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,108,248.30 | 6,956,927.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,158,227.92 | 1,861,115.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,388,768.35 | 14,771,495.73 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 282,831,001.00 | 296,201,980.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,196,701.00 | 21,592,013.98 |
| 210302 | Түлш, халаалт | 247,448,608.00 | 252,883,032.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,185,692.00 | 21,726,934.34 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 457,400.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 457,400.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 34,021,390.00 | 39,337,040.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,021,390.00 | 39,337,040.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,459,900.00 | 6,954,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,459,900.00 | 6,954,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,966,720.00 | 6,555,890.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,642,700.00 | 1,674,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,324,020.00 | 4,881,890.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,538,470.00 | 30,010,050.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,669,300.00 | 20,120,850.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,869,170.00 | 9,889,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,943,193.06 | 37,802,205.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 42,942,950.00 | 37,297,686.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 42,942,950.00 | 37,297,686.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 243.06 | 504,519.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 243.06 | 504,519.68 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 110,782,326.00 | 157,994,145.25 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 57,970,000.00 | 29,412,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 57,970,000.00 | 29,412,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 57,970,000.00 | 29,412,900.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 57,970,000.00 | 21,999,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 7,413,000.00 |

| | | | |
|----|--|-------------------------------|-------------------------------|
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(57,970,000.00)</u> | <u>(29,412,900.00)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 52,812,326.00 | 128,581,245.25 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 52,812,326.94 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 52,812,326.94 | 183,402,972.19 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-------------------------|---|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 122,700,000.00 | 4,191,093,436.68 | 4,313,793,436.68 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 122,700,000.00 | 4,191,093,436.68 | 4,313,793,436.68 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | 66,820,377.44 | 66,820,377.44 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 122,700,000.00 | 4,257,913,814.12 | 4,380,613,814.12 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 122,700,000.00 | 4,257,913,814.12 | 4,380,613,814.12 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | (42,648,873.59) | (42,648,873.59) |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 122,700,000.00 | 4,215,264,940.53 | 4,337,964,940.53 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | 257,631,360.95 | 257,631,360.95 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 122,700,000.00 | 4,472,896,301.48 | 4,595,596,301.48 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| | Үзүүлэлт | Тайлант оны | өрүү3 |
|--|----------|-------------|-------|
|--|----------|-------------|-------|

| Эдийн засгийн ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|-----------------------|--|-------------------------|-------------------------|------------------------|--------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,593,361,400.00 | 1,407,429,435.07 | 185,931,964.93 | 88.33 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,593,361,400.00 | 1,378,016,535.07 | 215,344,864.93 | 86.48 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,551,084,800.00 | 1,340,718,849.07 | 210,365,950.93 | 86.44 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,008,770,200.00 | 860,765,822.43 | 148,004,377.57 | 85.33 |
| 210101 | Үндсэн цалин | 707,687,700.00 | 643,351,904.42 | 64,335,795.58 | 90.91 |
| 210102 | Нэмэгдэл | 267,345,300.00 | 187,183,193.24 | 80,162,106.76 | 70.02 |
| 210104 | Урамшуулал | 33,737,200.00 | 30,230,724.77 | 3,506,475.23 | 89.61 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 126,096,900.00 | 100,893,566.32 | 25,203,333.68 | 80.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,746,100.00 | 69,246,942.60 | 16,499,157.40 | 80.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,087,700.00 | 8,057,085.22 | 2,030,614.78 | 79.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,070,100.00 | 6,956,927.10 | 1,113,172.90 | 86.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,017,600.00 | 1,861,115.67 | 156,484.33 | 92.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,175,400.00 | 14,771,495.73 | 5,403,904.27 | 73.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 296,410,200.00 | 296,201,980.32 | 208,219.68 | 99.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,800,000.00 | 21,592,013.98 | 207,986.02 | 99.05 |
| 210302 | Түлш, халаалт | 252,883,200.00 | 252,883,032.00 | 168.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,727,000.00 | 21,726,934.34 | 65.66 | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 39,735,400.00 | 39,337,040.00 | 398,360.00 | 99.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,735,400.00 | 39,337,040.00 | 398,360.00 | 99.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,250,800.00 | 6,954,500.00 | 296,300.00 | 95.91 |
| 210604 | Урсгал засвар | 7,250,800.00 | 6,954,500.00 | 296,300.00 | 95.91 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,746,100.00 | 6,555,890.00 | 4,190,210.00 | 61.01 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,583,000.00 | 1,674,000.00 | 1,909,000.00 | 46.72 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,163,100.00 | 4,881,890.00 | 2,281,210.00 | 68.15 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,075,200.00 | 30,010,050.00 | 32,065,150.00 | 48.34 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,330,500.00 | 20,120,850.00 | 31,209,650.00 | 39.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,744,700.00 | 9,889,200.00 | 855,500.00 | 92.04 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 42,276,600.00 | 37,297,686.00 | 4,978,914.00 | 88.22 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 42,276,600.00 | 37,297,686.00 | 4,978,914.00 | 88.22 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 42,276,600.00 | 37,297,686.00 | 4,978,914.00 | 88.22 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 29,412,900.00 | (29,412,900.00) | |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 29,412,900.00 | (29,412,900.00) | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 21,999,900.00 | (21,999,900.00) | |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 7,413,000.00 | (7,413,000.00) | |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,536,515,200.00 | 1,536,515,200.00 | - | 100.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,232,854,200.00 | 1,232,854,200.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,232,854,200.00 | 1,232,854,200.00 | - | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 303,661,000.00 | 303,661,000.00 | - | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 303,661,000.00 | 303,661,000.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|--|----------------|------------------|--|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 52,812,326.94 | (52,812,326.94) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 183,402,972.19 | (183,402,972.19) | |

, БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 1 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 78,557.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, нийт 21,536.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,528.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,044.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 12,962.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Багш ажилтанд 4,528.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, мөнгөн урамшуулал, илүү цагийн хөлсийг тушаал шийдвэрт заасан хувь хэмжээнээс илүү тооцсон, давхардуулж олгосон. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4.3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, 2 дугаар хавсралтын 3.2-т “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасныг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж, 1,705.0 мянган төгрөг зарцуулсан нь БШУС, Эрүүл мэндийн сайдын 2022 оны хамтарсан А/328, 1/340 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах” тухай журмын 1-д заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

2. Дотуур байр, үдийн хоолны өдөрлөгт хүүхдийн тоог ирцийн бүртгэлээс зөрүүтэй бичиж 946.0 мянган төгрөг илүү зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

3. Үдийн хоолны өдөрлөгт хүүхдийн тоог ирцийн бүртгэлээс зөрүүтэй бичиж 1,393.0 мянган төгрөг илүү зарцуулсан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих дараах асуудалд зөвлөмж өгсөн. Үүнд:

Илрүүлэлт:

